

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/311/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэл осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 21/125
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.БАДАМЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Аргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 сарын 21-ны өдрийн 241 тоот тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох” албан хаагчдын цалингийн хэмжээнд өөрчлөлт орсон байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Тайлант 16,764.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

019020218

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	100,181,164.70	109,902,366.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,760,071.90	43,386,746.36
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	20,760,071.90	43,386,746.36
3121	Төгрөг	20,760,071.90	43,386,746.36
31	Төрийн сангийн харилцах	20,760,071.90	43,386,746.36
33	АВЛАГА	59,750.00	
335	Бусад авлага	59,750.00	
3351	Байгууллагаас авах авлага	59,750.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	79,361,342.80	66,515,620.40
354	Хангамжийн материал	79,361,342.80	66,515,620.40
35410	Бичиг хэргийн материал	1,308,450	450,000.00
35420	Аж ахуйн материал	75,000.00	0.00
35440	Түлш шатах тослох материал	16.93	16.93
35450	Барилга засварын материал	1,000,000.00	
35460	Хүнсний материал	3,835,815.00	2,748,975.00
35470	Бусад хангамжийн материал	73,142,060.87	63,316,628.47
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,520,238,680.26	1,545,096,063.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,520,238,680.26	1,545,096,063.42
392	Биет хөрөнгө	1,477,438,680.26	1,502,296,063.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,305,577,251.79	1,305,577,251.79
39202	Хуримтлагдсан элэгдэл	(48,046,862.27)	(49,699,443.71)
39205	Машин тоног төхөөрөмж	138,747,180.84	169,684,180.84
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13,490,750.29)	(18,192,055.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,387,301.75	97,096,701.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,617,091.21)	(17,971,094.53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,189,370.00	4,189,370.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,225,016.82)	(1,306,143.51)
39217	Номын фонд	12,917,296.47	12,917,296.47
393	Биет бус хөрөнгө	42,800,000.00	42,800,000.00
39301	Программ хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	(750,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	42,800,000.00	42,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,620,419,844.96	1,654,998,430.18
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	608,986.11	3,555,722.76
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	608,986.11	3,555,722.76
413	Өглөг	608,986.11	3,555,722.76
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	608,986.11	3,555,722.76
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,619,810,858.85	1,651,442,707.42
51	Засгийн газрын хувь оролцоо	1,619,810,858.85	1,651,442,707.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	309,078,461.60	309,078,461.60
51101	Өмч:-төрийн	479,943,460.99	479,943,460.99
512	Хуримтлагдсан үр дүн	795,997,837.84	827,629,686.41
51210	Өмнөх үеийн үр дүн	795,997,837.84	795,997,837.84
51220	Тайлант үеийн үр дүн		31,631,848.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	514,734,559.41	514,734,559.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,620,419,844.96	1,654,998,430.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,401,680,820.43	892,616,067.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,586,560,420.43	16,764,119.60
120	Нийтлэг татварын бус орлого	1,586,560,420.43	16,764,119.60
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,509,629,017.61	15,926,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	76,931,402.82	838,119.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	815,120,400.00	875,851,949.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	634,608,900.00	722,333,048.00
1320	Орон нутгийн санхүүжилт	121,599,000.00	153,518,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутаг/	121,599,000.00	153,518,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,912,500.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	58,912,500.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	781,433,708.66	860,984,219.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	781,433,708.66	860,984,219.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	684,971,038.06	834,445,712.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	459,165,504.94	535,499,572.47
210101	Үндсэн цалин	328,833,849.88	389,717,854.04
210102	Нэмэгдэл	100,464,115.20	118,168,576.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт		75,000.00
210104	Урамшуулал	29,867,539.86	27,538,142.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,160,650.56	68,774,322.07
210201	Тэтгэврийн даатгал	39,292,541.66	47,826,849.39
210202	Тэтгэмжийн даатгал	4,623,461.69	5,480,738.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,692,414.94	4,327,390.81
210204	Ажилгүйдлийн даатгал	870,073.24	1,004,828.90
210205	Эрүүл мэндийн даатгал	8,682,159.03	10,134,514.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,482,886.11	155,465,616.65
210301	Гэрэл, цахилгаан	7,853,386.11	11,846,736.65
210302	Түлш, халаалт	91,429,500.00	143,418,880.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		11,353,552.00
210408	Бараа материал акталсны зардал		11,353,552.00
2105	Норматив зардал	29,473,176.00	26,948,084.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,992.00	
210502	Хоол, хүнс	29,373,184.00	26,948,084.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,000,000.00
210604	Урсгал засвар		2,000,000.00

Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,260,000.00	4,844,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,033,300.00
210806	Мэдээлэл технологийн	1,260,000.00	3,811,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,428,820.45	29,559,764.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,465,236.02	13,465,098.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,857,500.00	6,305,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,106,084.43	9,789,016.84
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,462,670.60	26,538,507.00
	Бусад урсгал шилжүүлэг	96,462,670.60	26,538,507.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж зардал	21,172,557.00	21,544,491.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,465,800.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,965,999.00	4,993,996.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч	29,446,700.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,411,614.60	20.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,411,614.60	20.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,620,247,111.77	31,631,848.57
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	436,252.92	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	436,252.92	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(436.252.92)	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,619,810,858.85	31,631,848.57

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	815,120,400.00	875,851,948.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	815,120,400.00	875,851,948.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	815.120.400.00	875,851,948.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	634,608,900.00	722,333,048.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	634,608,900.00	722,333,048.00
1320	Орон нутгийн санхүүжилт	121,599,000.00	153,518,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутаг/	121,599,000.00	153,518,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,912,500.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	58,912,500.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	766,373,328.10	834,504,873.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	766,373,328.10	834,504,873.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	672,958,76.50	805,982,577.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	459,165,504.32	535,682,394.54
210101	Үндсэн цалин	328,830,268.99	373,127,578.26
210102	Нэмэгдэл	100,467,695.47	138,314,317.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт		75,000.00
210104	Урамшуулал	29,867,539.86	24,165,498.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,160,651.18	68,591,500.00
210201	Тэтгэврийн даатгал	39,283,673.01	46,641,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,619,551.36	5,487,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,687,241.07	4,389,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	869,558.71	1,097,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,700,627.03	10,974,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,873,900.00	152,518,880.00
210301	Гэрэл, цахилгаан	7,244,400.00	8,900,000.00
210302	Түлш, халаалт	91,429,500.00	143,418,880.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00
2105	Норматив зардал	33,268,675.00	23,877,455.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,268,675.00	23,877,455.00
210502	Хоол, хүнс	33,268,675.00	23,877,455.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,260,000.00	4,874,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,033,300.00
210806	Мэдээлэл технологийн зардал	1,260,000.00	3,841,500.00

Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,230,039.00	19,437,548.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,525,289.00	13,990,348.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,704,750.00	5,447,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,414,558.6	28,522,296.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,002,944.00	28,522,276.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	18,064,695.00	23,528,280.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,465,800.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,025,749.0	4,993,996.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч	29,446,700.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,411,614.60	20.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,411,614.60	20.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	48,747,071.90	41,347,074.46
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,987,000.00	18,720,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,987,000.00	18,720,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,987,000.00	18,720,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,987,000.00	18,720,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(27,987,000.00)	(18,720,400.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20,760,07.90	22,626,674.46
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		20,760,071.90
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,760,071.90	43,386,746.36

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	266,278,461.60	469,939,819.37	(177,709,348.55)	558,508,932.42
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			15,000.00	15,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	266,278,461.60	469,939,819.37	(177,694,348.55)	558,523,932.42
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн		(15,000.00)		(15,000.00)
Тайлант үеийн үр дүн			2,519,549.90	2,519,549.90
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309,078,461.60	514,734,559.41	795,997,837.84	1,619,810,858.85
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн	309,078,461.60	514,734,559.41	795,997,837.84	1,619,810,858.85
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			31,631,848.57	31,631,848.57
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309,078,461.60	514,734,559.41	827,629,686.41	1,651,442,707.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		20,760,071.90		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	885,064,500.00	853,225,253.50	31,839,246.46	96.4%
УРСГАЛ ЗАРДАЛ	885,064,500.00	853,225,253.54	31,839,246.46	96.4%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	850,676,800.00	824,702,977.54	25,973,822.46	96.9%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	552,141,700.00	535,682,394.50	16,459,305.46	97.0%
Үндсэн цалин	390,313,900.00	373,127,578.26	17,186,321.74	95.6%
Нэмэгдэл	142,117,900.00	138,314,317.44	3,803,582.56	97.3%
Унаа хоолны хөнгөлөлт		75,000.00	(75,000.00)	
Урамшуулал	19,709,900.00	24,165,498.84	(4,455,598.84)	122.6%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	70,352,700.00	68,59,500.00	1,761,200.00	97.5%
Тэтгэврийн даатгал	47,840,000.00	46,641,800.00	1,198,200.00	97.5%
Тэтгэмжийн даатгал	5,628,100.00	5,487,600.00	140,500.00	97.5%
ҮОМШӨ-ний даатгал	4,502,500.00	4,389,700.00	112,800.00	97.5%
Ажилгүйдлийн даатгал	1,125,700.00	1,097,800.00	27,900.00	97.5%
Эрүүл мэндийн даатгал	11,256,400.00	10,974,600.00	281,800.00	97.5%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	152,518,900.00	152,518,880.00	20.00	100%
Гэрэл, цахилгаан	8,900,000.00	8,900,000.00		100%
Түлш, халаалт	143,418,900.00	143,418,880.00	20.00	100%
Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00		100%
Норматив зардал	32,241,100.00	23,877,455.00	8,363,645.00	74.1%
Хоол, хүнс	32,241,100.00	23,877,455.00	8,363,645.00	74.1%
Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0%
Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,022,800.00	4,874,800.00	(852,000.00)	121.2%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	181,300.00	1,033,300.00	(852,000.00)	569.9%
Мэдээлэл технологийн зардал	3,841,500.00	3,841,500.00	-	100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	38,399,600.00	38,157,948.00	241,652.00	99.4%
Бараа үйлчилгээний бусад зардал	32,637,400.00	32,395,748.00	341,652.00	99.3%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,762,200.00	5,762,200.00		100%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,387,700.00	28,522,276.00	5,865,424.00	82.9%
Бусад урсгал шилжүүлэг	34,387,700.00	28,522,276.00	5,865,424.00	82.9%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	29,393,700.00	23,528,280.00	5,865,420.00	80.0%
Нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,994,000.00	4,993,996.00	4.00	100.0%

Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	878,579,700.00	875,851,948.00	2,727,752.00	99.7%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	725,060,800.00	722,333,048.00	2,727,752.00	99.6%
Улсын төсвөөс санхүүжих	725,060,800.00	722,333,048.00	2,727,752.00	99.6%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	153,518,900.00	153,518,900.00	-	100.0 %
Орон нутгийн төсвөөс санхүүжих	153,518,900.00	153,518,900.00		100.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		20,760,071.90		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		43,386,746.36		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	23	23		
Үйлчлэх ажилтан	10	10		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Аргалант сумын ерөнхий боловсролын сургууль нь 2022-2023 оны хичээлийн жилд “Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тэгш боломж бүрдүүлэх, сурагчдын сонирхолд тулгуурлан сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг эзэмшүүлэх” зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Монгол улсын Бага, дунд боловсролын тухай хуульд бага, суурь, бүрэн дунд боловсролын зорилгыг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх;
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх;
- Бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх; гэж тодорхойлсон.

Төв аймгийн Аргалант сумын ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 12 зорилт, хэрэгжүүлэх 81 арга хэмжээтэй баталснаас нийт 90.0 %-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Аргалант сумын ерөнхий боловсролын сургууль нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалтын ажил хийгдээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Аргалант сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Аргалант сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,578.5 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20,760.1	43,386.7	22,626.6
Авлага	59.8		(59.8)
Бараа материал	79,361.3	66,515.6	(12,845.7)
Үндсэн хөрөнгө	1,520,238.7	1,545,096.1	24,857.4
Нийт хөрөнгө	1,620,419.9	1,654,998.4	34,578.5
Өр төлбөр	608.9	3,555.6	2,946.7
Засгийн газрын хувь оролцоо	1,619,810.9	1,651,442.8	31,631.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,620,419.9	1,654,998.4	34,578.5

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 22,626.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийг бүрэн зарцуулсантай холбоотой.

Бараа материал дансны хувьд 66,515.6 мянган төгрөг болж 12,845.7 мянган төгрөгөөр буурсан нь хүнсний бараа материал 1,086.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, бусад хангамжийн материалаас 11,353.5 мянган төгрөгөөр акталснаар буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд тоног төхөөрөмж 30,937.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 3,709.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 16,471.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 2,249.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 15,926.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,946.7 мянган төгрөгөөр өссөн нь байр ашиглалттай холбоотой цахилгааны зардлыг төлж барагдуулаагүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,654,998.4 мянган төгрөг болж 31,631.9 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 493,319.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Аргалант сумын ерөнхий боловсролын сургууль нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 231,741.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 725,060.8 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 725,060.8 мянган төгрөгөөс 8 удаа тодотгол хийж 722,333.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 722,333.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зарцуулсан байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 722,333.1 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байна.

Хүснэгт 2.

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	1,536.0	1,536.0	0	100%
1.2	80312 Сургалт семинар	773.1	768.3	4.8	100%
1.3	81605 Эрүүл мэндийг дэмжих	1,953.6	1,800.0	153.6	92.0%
1.4	81801 Үдийн цай хөтөлбөр	29,393.7	23,525.2	5,868.4	80.0%
1.5	81806 Дотуур байрны үйлчилгээ	58,117.4	42,859.0	10,259.6	100.0%
1.6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	15,915.3	15,900.3	15.0	100.0%
1.7	81823 Багшийн ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	3,519.3	3,431.7	87.6	97.0%
1.8	81827 Бичиг үсгийн боловсрол	7,244.9	7,244.9	0	100
1.9	81834 Боловсрол стандарт сургалтын төлөвлөгөө-цалин	544,166.1	529,151.8	24,351.2	97.0%
1.10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	68,543.4	67,231.0	2,651.0	97.0%
1.11	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	15,900.3	15,900.3		100%
1.12	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	150.6	150.6		99.0%
1.13	81848 Түрээсийн сурах бичиг	1,033.3	1,033.3		43.0%
	Дүн	725,060.8	699,063.7	43,386.7	96.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Аргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 105,075.9 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ

худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: үдийн цай болон дотуур байрны хүүхдийн хоол хүнс 61,634.8 мянган төгрөгөөр нээлттэй тендер шалгаруулахаар, 32,637.4 төгрөгийн бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, бараа үйлчилгээний бусад зардал, мэдээлэл технологийн зардлуудыг шууд худалдан авалтаар, 203,998.6 төгрөгийн тогтмол зардлыг шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 105,075.7 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу хийсэн байна. Худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар эцэг, эхчүүд болон иргэд, байгууллага, төгсөгчдөөс авсан хандив тусламжаар үндсэн хөрөнгө, бараа материалыг авахдаа “Сургууль цэцэрлэг хөгжүүлэх сан”-ийн үлгэрчилсэн дүрмийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав нар хэрэгжүүлж, дараагийн шатны хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлага 781,433.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 11,721.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,791.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Аргалант сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож, 148 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 5 мэдээллийн хугацаа болоогүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж, 5 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 40 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	168,965.4	5	168,965.4	100%
Зөвлөмж	4	9,084.8	4	9,084.8	100%
Нийт дүн	9	178,050.2	9	178,050.2	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,407.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1. Тайлант онд гэрэл цахилгааны өглөг 3,555.7 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өр, төлбөр үүсгэхгүй төсвийг зохистой удирдах албан шаардлага хүргүүлэх.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 852.0 мянган төгрөгөөр төсвийн гүйцэтгэлийг хэтрүүлэн тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах, санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хандив тусламжийн хөрөнгийг бүртгэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд эцэг, эхчүүд болон иргэд, байгууллага, төгсөгчдөөс авсан хандив тусламжаар үндсэн хөрөнгө, бараа материалыг авахдаа "Сургууль цэцэрлэг хөгжүүлэх сан"-ийн үлгэрчилсэн дүрмийг хэрэгжүүлж ажиллаагүй нь Боловсролын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 Боловсролын санхүүжилт нь улс, орон нутгийн төсөв, сургалтын төлбөр, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагаас дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, тусламж, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ; Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 дугаар тушаалын 1.1 Өмчийн хэлбэр харгалзахгүй их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль /цаашид сургууль гэх/, цэцэрлэгт дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн, эцэг эх, асран хамгаалагч, сайн дурын байгууллагаас /цаашид хандивлагч болон тусламж үзүүлэгч гэх/ санаачлан сайн дурын үндсэн дээр тухайн байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулан өгсөн хандив, буцалтгүй тусламжийн орлогыг "Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сан"-д бүртгэж авах, зарцуулах, хяналт тавих, мэдээ тайланд тусгах харилцааг энэхүү дүрмээр зохицуулна" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хандив тусламжийн хөрөнгийг бүртгэхтэй холбогдох хуулийг хэрэгжүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд гэрэл цахилгааны өглөг 3,555.7 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн	1	3,555.7			1	3,555.7						
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 852.0 мянган төгрөгөөр төсвийн гүйцэтгэлийг хэтрүүлэн тайлагнасан	1	852.0			1	852.0						
Хандив тусламжаар орлогыг хүлээн авч сан байгуулан ажиллах	1	-					1	-				
Дүн	3	4,407.7			2	4,407.7	1	-				



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 104-17225502-ТӨА-2024/213/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гэрэл цахилгааны төлбөр 3,555,722.76 төгрөгийн өглөг үүсгэж ажилласан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг, Санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өр төлбөрийн тооцоог хянаж, баталгаажуулах, өр төлбөр үүсгэхгүй байх, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Бадамцэцэг, нягтлан бодогч Б.Ариунгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар _____

107-17225502-ТӨА-2024/311/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 852,000.00 төгрөгөөр төсвийн гүйцэтгэлийг хэтрүүлэн тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,” гэж заасныг, Санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.5-д “төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Бадамцэцэг, нягтлан бодогч Б.Ариунгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ